

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал.....	9
3.1	Орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар .....	9
3.2	Зардлын талаар .....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ  
ДАРГА А.НАМСАМАНД ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/304  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус албаны дарга А.Намсаманд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлого, зардлын бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Отгонхорлоо хариуцаж хэрэгжүүлэв.

Шийдвэр гүйцэтгэх алба нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 4/117 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шийдвэр гүйцэтгэх албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Шийдвэр гүйцэтгэх алба нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, цахим сан бүрдүүлэх, лавлагаа мэдээлэл олгох, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг шийдвэрлэх гэсэн эрхэм зорилгын хүрээнд ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Шийдвэр гүйцэтгэх албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.  
Үүнд:

- Аймаг, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих
- Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг бусад байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ талаар нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, хяналт тавих
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар Улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтлөх
- Аймаг, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны талаар гарсан гомдлыг шийдвэрлэх.

Шийдвэр гүйцэтгэх албаны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Шийдвэр гүйцэтгэх албаны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Тайлант хугацаанд эрх зүйн орчны талаар томоохон өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Шийдвэр гүйцэтгэх албаны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Шийдвэр гүйцэтгэх алба нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Шийдвэр гүйцэтгэх албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Шийдвэр гүйцэтгэх албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг

сонгосон. Гүйцэтгэлийн үе шатанд 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувь болох 17,774.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн ба аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/ Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	91,961.4	
	Дүн	2	91,961.4	

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудалд зөвлөмж өгөхөөр Менежментийн захидалд оруулсан бөгөөд, бусад хэлбэрээр шийдсэн алдаа байхгүй болно.

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах бусад чухал асуудал гараагүй болно.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шийдвэр гүйцэтгэх албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 7 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 660,009.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.



Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 659,854.2 мянган төгрөг бөгөөд нэмэгдэл цалин, бичиг хэргийн зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлуудыг тус тус хэмнэж, 155.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Шийдвэр гүйцэтгэх алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу Шийдвэр гүйцэтгэх алба нь 2018 онд 120 мэдээллээс иж бүрэн оруулж, нийтэд мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх онуудад түүвэрт хамрагдаж тусгайлан дүгнэлт гараагүй бөгөөд зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шийдвэр гүйцэтгэх албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар**

##### 3.1.1 Илрүүлэлт:

2018 оны үйл ажиллагааны орлого буюу лавлагааны орлого 83,592.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэлгүйгээр туслах үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх.

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж үндсэн үйл ажиллагааны орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлж байх.

##### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу:

Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, баталгаажуулсан болно.

#### **3.2 Зардлын талаар**

##### 3.2.1 Илрүүлэлт

Тус байгууллагын дарга ШШГЕГ-ын даргын гадаад албан томилолтын А/163, А/120 дугаар тушаалууд гадаадад томилолтоор ажиллахдаа 8.3 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас томилолтын зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, уг томилолтоор ажилласантай холбоотой анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу:

Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	56,738,342.50	51,620,685.98
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		967,700.00
Кассад байгаа бэлэн мөнгө		967,700.00
Төгрөг		967,700.00
БАРАА МАТЕРИАЛ	56,738,342.50	50,652,985.98
Хангамжийн материал	56,738,342.50	50,652,985.98
Бичиг хэргийн материал	11,469,890.00	5,531,350.00
Аж ахуйн материал	19,866,225.50	24,329,131.27
Сэлбэг хэрэгсэл	5,361,000.00	1,196,000.00
Түлш,шатах тослох материал	3,559,595.00	5,301,332.71
Барилгын засварын материал	515,000.00	515,000.00
Хүнсний материал	1,186,000.00	1,410,800.00
Бусад хангамжийн материал	14,780,632.00	12,369,372.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	903,362,296.93	916,673,823.13
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	903,362,296.93	916,673,823.13
Биет хөрөнгө	853,913,370.56	850,580,792.84
Барилга,байгууламж,орон сууц	639,077,566.00	619,740,373.32
Хуримтлагдсан элэгдэл	(149,411,109.49)	
Авто-тээврийн хэрэгсэл	192,174,000.00	103,800,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(94,011,488.87)	(46,503,888.77)
Машин,тоног төхөөрөмж (компьютер)	410,329,294.36	325,023,088.36
Хуримтлагдсан элэгдэл	(202,459,279.36)	(194,231,246.89)
Тавилга, аж ахуйн эд хогшил	85,874,713.30	65,675,979.00
Хуримтлагдсан элэгдэл	(28,060,325.38)	(28,202,470.23)
Бусад үндсэн хөрөнгө	400,000.00	7,050,000.00
Хуримтлагдсан элэгдэл		(1,771,041.95)
Биет бус хөрөнгө	49,448,926.37	66,093,030.29
Програм хангамж	209,996,384.62	53,980,384.62
Хуримтлагдсан элэгдэл	(160,547,458.25)	(18,026,554.33)
Бусад биет бус хөрөнгө		30,139,200.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	960,100,639.43	968,294,509.11
ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	960,100,639.43	968,294,509.11
Засгийн газрын хувь оролцоо	960,100,639.43	968,294,509.11
Засгийн газрын оруулсан капитал		30,139,200.00
Хуримтлагдсан үр дүн	960,100,639.43	787,755,150.09
Өмнөх үеийн үр дүн	960,100,639.43	960,100,639.43
Тайлант үеийн үр дүн		(172,345,489.34)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		150,400,159.02
НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	960,100,639.43	968,294,509.11

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	990,604,417.12	716,356,252.28
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	363,081,697.12	98,518,832.86
Нийтлэг татварын бус орлого	363,081,697.12	98,518,832.86
Төсөв байгууллагын өөрийн орлого	363,081,697.12	98,518,832.86
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	353,842,680.00	97,475,615.09
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,239,017.12	1,043,217.77
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	627,522,720.00	617,837,419.42
Улсын төвлөрсөн төсвөөс	469,911,500.00	562,551,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	469,911,500.00	562,551,800.00
Төсвийн захирагчдаас	157,611,220.00	55,285,619.42
Хөрөнгийн	157,611,220.00	55,285,619.42
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	839,530,719.94	765,630,440.71
УРСГАЛ ЗАРДАЛ	839,530,719.94	765,630,440.71
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	825,569,980.88	763,975,953.07
ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	319,134,312.77	316,323,603.56
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	311,049,230.86	308,051,128.73
Үндсэн цалин	213,968,533.61	215,229,053.37
Нэмэгдэл	93,155,597.25	87,610,475.36
Унаа хоолны хөнгөлөлт	3,925,100.00	4,701,600.00
Урамшуулал	0.00	510,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,085,081.91	8,272,474.83
Тэтгэврийн даатгал	1,536,385.56	724,815.09
Эрүүл мэндийн даатгал	6,109,729.04	7,547,659.74
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,279,982.07	16,650,178.62
Гэрэл, цахилгаан	9,976,479.00	9,722,896.80
Түлш, халаалт	6,896,571.00	5,714,060.00
Цэвэр, бохир ус	1,406,932.07	1,213,221.82
Хангамж, бараа материалын зардал	59,847,956.72	68,635,830.29
Бичиг хэрэг	18,607,055.00	14,917,088.00
Тээвэр, шатахуун	14,335,700.00	10,303,100.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	13,958,425.92	18,300,656.29
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	639,000.00	640,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,343,173.50	7,721,786.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	4,194,802.30	12,491,200.00
Бараа материал акталсны зардал	769,800.00	4,262,000.00
Нормативт зардал	7,913,509.50	5,215,000.00
Хоол, хүнс	7,913,509.50	5,215,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	47,128,684.00	27,985,450.00
Багаж, техник, хэрэгсэл	60,000.00	148,500.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	211,000.00
Урсгал засвар	47,068,684.00	27,625,950.00
Томилолт, зочны зардал	4,590,400.00	4,435,800.00
Дотоод албан томилолт	4,590,400.00	4,435,800.00

Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	195,242,050.00	174,855,945.27
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,838,800.00	173,372,025.27
Тээврийн хэрэгслийн татвар	708,350.00	423,020.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	66,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500.00	909,500.00
Газрын төлбөр	85,400.00	85,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал	173,433,085.82	149,874,145.33
Бараа үйлчилгээний бусад зардал	10,045,645.50	5,594,500.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,680,900.00	12,787,500.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	154,706,540.32	131,492,145.33
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,960,739.06	1,654,487.64
Бусад урсгал шилжүүлэг	13,959,000.00	1,499,111.20
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,959,000.00	1,499,111.20
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,739.06	155,376.44
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	155,376.44
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	151,073,697.18	-49,274,188.43
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	102,495,033.91	123,071,300.91
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	38,548,233.91	108,221,300.91
Үнэ төлбөргүй гарсан зардал	63,946,800.00	14,850,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	48,578,663.27	-172,345,489.34

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	823,754,180.00	660,009,600.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	353,842,680.00	97,457,800.00
Нийтлэг татварын бус орлого	353,842,680.00	97,457,800.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	353,842,680.00	97,457,800.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	353,842,680.00	97,457,800.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	469,911,500.00	562,551,800.00
Улсын төвлөрсөн төсвөөс	469,911,500.00	562,551,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	469,911,500.00	562,551,800.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	763,726,026.00	641,841,906.00
УРСГАЛ ЗАРДАЛ	763,726,026.00	641,841,906.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	753,155,286.94	640,187,418.36
ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	315,402,351.65	316,305,788.47
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	307,317,269.74	308,051,128.73
Үндсэн цалин	214,610,002.24	215,229,053.37
Нэмэгдэл	89,214,267.50	87,610,475.36
Унаа хоолны хөнгөлөлт	2,493,000.00	4,701,600.00
Урамшуулал	1,000,000.00	510,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,085,081.91	8,254,659.74
Тэтгэврийн даатгал	8,085,081.91	707,000.00
Эрүүл мэндийн даатгал	0.00	7,547,659.74
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,279,982.07	16,650,178.62
Гэрэл, цахилгаан	9,976,479.00	9,722,896.80
Түлш, халаалт	6,896,571.00	5,714,060.00
Цэвэр, бохир ус	1,406,932.07	1,213,221.82
Хангамж, бараа материалын зардал	61,878,819.42	52,687,000.00
Бичиг хэрэг	22,189,975.00	14,561,748.00
Тээвэр, шатахуун	15,732,630.00	11,784,595.71
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	13,958,425.92	18,300,656.29
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	639,000.00	640,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,358,788.50	7,400,000.00
Нормативт зардал	13,337,301.80	14,711,000.00
Хоол, хүнс	13,337,301.80	14,711,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	110,764,170.00	36,016,006.00
Багаж, техник, хэрэгсэл	59,944,086.00	880,006.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	386,000.00
Урсгал засвар	50,820,084.00	34,750,000.00
Томилолт, зочны зардал	4,599,400.00	4,435,800.00
Дотоод албан томилолт	4,599,400.00	4,435,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	202,166,250.00	179,444,345.27
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	199,993,000.00	177,704,925.27
Тээврийн хэрэгслийн татвар	708,350.00	423,020.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	66,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,324,500.00	1,165,000.00

Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Газрын төлбөр	85,400.00	85,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал	26,727,012.00	19,937,300.00
Бараа үйлчилгээний бусад зардал	12,419,062.00	5,594,500.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,307,950.00	14,342,800.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,570,739.06	1,654,487.64
Бусад урсгал шилжүүлэг	10,569,000.00	1,499,111.20
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,569,000.00	1,499,111.20
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,739.06	155,376.44
Төвлөрүүлэх шилжүүлэг		155,376.44
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	60,028,154.00	18,167,694.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	60,028,154.00	17,199,994.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,028,154.00	17,199,994.00
Дотоод эх үүсвэрээр	60,028,154.00	17,199,994.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	60,028,154.00	17,199,994.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-60,028,154.00	-17,199,994.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		967,700.00
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		967,700.00



#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн /төгрөгөөр/
2016 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл			911,497,476.19	911,497,476.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			24,499.97	24,499.97
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлангийн үеийн үр дүн			48,578,663.27	48,578,663.27
2017 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл			960,100,639.43	960,100,639.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	30,139,200.00			30,139,200.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,139,200.00		960,100,639.43	990,239,839.43
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		150,400,159.02		150,400,159.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлангийн үеийн үр дүн			-172,345,489.34	-172,345,489.34
2018 оны 12 сарын 31-р үлдэгдэл	30,139,200.00	150,400,159.02	787,755,150.09	968,294,509.11

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	660,009,600.00	658,886,523.56	1,123,076.44	99.83
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	660,009,600.00	658,886,523.56	1,123,076.44	99.83
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	658,509,600.00	657,387,412.36	1,122,187.64	99.83
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,081,900.00	341,081,623.89	1,000,276.11	99.71
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	308,167,000.00	308,051,128.73	115,871.27	99.96
Үндсэн цалин	214,111,500.00	215,229,053.37	-	100.52
Нэмэгдэл цалин	89,829,500.00	87,610,475.36	2,219,024.64	97.53
Унаа хоолны нэмэгдэл	3,226,000.00	4,701,600.00	-	145.74
Урамшуулал	1,000,000.00	510,000.00	490,000.00	51.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,260,700.00	8,254,659.74	6,040.26	99.93
Тэтгэврийн даатгал	0.00	707,000.00	-707,000.00	0.00
Эрүүл мэндийн даатгал	8,260,700.00	7,547,659.74	713,040.26	91.37
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,650,400.00	16,650,178.62	221.38	100.00
Гэрэл, цахилгаан	9,722,900.00	9,722,896.80	3.20	100.00
Түлш, халаалт	5,714,200.00	5,714,060.00	140.00	100.00
Цэвэр, бохир ус	1,213,300.00	1,213,221.82	78.18	99.99
Хангамж, бараа материалын зардал	52,687,000.00	52,687,000.00	0.00	100.00
Бичиг хэрэг	16,135,000.00	14,561,748.00	1,573,252.00	90.25
Тээвэр, шатахуун	11,035,400.00	11,784,595.71	-749,195.71	106.79
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	17,476,600.00	18,300,656.29	-824,056.29	104.72
Хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	640,000.00	640,000.00	0.00	100.00
БҮТЭЗҮЙЛС	7,400,000.00	7,400,000.00	0.00	100.00
Нормативт зардал	14,711,000.00	14,711,000.00	0.00	100.00
Хоол хүнс	14,711,000.00	14,711,000.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	53,216,000.00	53,216,000.00	0.00	100.00
Багаж, техник хэрэгсэл	16,280,000.00	16,280,000.00	0.00	100.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	470,000.00	386,000.00	84,000.00	82.13
Урсгал засвар	36,466,000.00	36,550,000.00	-84,000.00	100.23
Томилолт, зочны зардал	4,450,000.00	4,435,800.00	14,200.00	99.68
Дотоод албан томилолт	4,450,000.00	4,435,800.00	14,200.00	99.68
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,462,500.00	179,444,345.27	18,154.73	99.99
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	177,723,000.00	177,704,925.27	18,074.73	99.99
Тээврийн хэрэгслийн татвар	423,100.00	423,020.00	80.00	99.98
Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	0.00	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,165,000.00	1,165,000.00	0.00	100.00
Газрын төлбөр	85,400.00	85,400.00	0.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	20,905,000.00	19,937,300.00	967,700.00	95.37
Бараа үйлчилгээний бусад зардал	5,594,500.00	5,594,500.00	0.00	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,310,500.00	14,342,800.00	967,700.00	93.68
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,499,111.20	888.80	99.94

Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,499,111.20	888.80	99.94
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,499,111.20	888.80	99.94
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>660,009,600.00</b>	<b>659,854,223.56</b>	<b>155,376.44</b>	<b>99.98</b>
Туслах үйл ажиллагааны орлого	97,457,800.00	97,457,800.00	0.00	100.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>562,551,800.00</b>	<b>562,396,423.56</b>	<b>155,376.44</b>	<b>99.97</b>
Улсын төсвөөс санхүүжих	562,551,800.00	562,396,423.56	155,376.44	99.97
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>0.00</b>	<b>967,700.00</b>	<b>-967,700.00</b>	<b>0.00</b>

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

### Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

#

<b>Огноо:</b>	<b>2018 он</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн тайлангийн аудит</b>	<b>САГ-2019/347/СТА-ТШЗ</b>
<b>Шалгагдсан байгууллагын</b>	<b>Шийдвэр гүйцэтгэх алба</b>		<b>мянган төгрөгөөр</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	2018 оны үйл ажиллагааны орлого буюу лавлагааны орлого 83,592.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэлгүйгээр туслах үйл ажиллагаанд зарцуулсан байна.	83,592.6	Зөвлөмж хүргүүлэх	ШГА-ны дарга ШГА-ны Ахлах нягтлан бодогч	Д.Дамдинцэрэн З.Оюундалай
2	Тус байгууллагын дарга ШШГЕГ-ын даргын гадаад албан томилолтын А/163, А/120 дугаар тушаалууд гадаадад томилолтоор ажиллахдаа 8.3 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас томилолтын зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, уг томилолтоор ажилласантай холбоотой анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	8,368.8	Зөвлөмж хүргүүлэх	ШГА-ны дарга ШГА-ны Ахлах нягтлан бодогч	Д.Дамдинцэрэн З.Оюундалай
<b>Дүн</b>		<b>91,961.4</b>			